



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/116/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Багийн ахлагч аудитор:	Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn
	Аудитор:	Д.Дэмбэрэлсүрэн
		Цахим хаяг: demberelsurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Бэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.08.26 № 1-6/135

танай _____ -ны № _____ -т

ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ СУМ
ДУНДЫН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
ХОШУУЧ Г.ПҮРЭВДЭЛГЭР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-үүд сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-үүд сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

This PC: D/2022 onii ajil/A4 toot

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	107.5	133.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,221.4	1,276.7
	Нийт хөрөнгийн дүн	1,328.9	1,409.9
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,328.9	1,409.9
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,328.9	1,409.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,190.9	1,336.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,199.6	1,255.2
	Үйл ажиллагааны үр дүн	(8.7)	(80.9)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(8.7)	(80.9)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,337.6	1,328.9
	Тайлант оны үр дүн	(8.7)	80.9
	Эцсийн үлдэгдэл	1,328.9	1,409.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,083.9	1,142.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,063.9	1,142.9
	Үйл ажиллагааны ЦМГ	20.0	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(20.0)	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,135.6	1,135.3
	Урсгал зардал	1,135.6	1,135.3
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,135.6	1,135.3
	Улсын төсвөөс санхүүжих	1,132.6	1,132.6
	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3.0	2.7

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Замын-Үүд сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс нь “Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах” үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг байна.

Цагдаагийн ерөнхий газраас дараах зорилго, зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.
Үүнд:

1. “Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах”

2. “Үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, шуурхай байдлыг хангах”

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант оны санхүүгийн тайлан, үйл ажиллагаанд онцлох болон бусад асуудал илэрсэнгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тус байгууллагад тайлант онд Замын-Үүд сумын ЗДТГ-аас 20.0 сая төгрөгийн үнэ бүхий Приус-20 маркийн автомашин, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн балансаас баланст ЦЕГ-аас 1, НЦГ-аас 1 авто машин, өөрийн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1 автомашиныг дахин үнэлж нийт 4 автомашиныг данс бүртгэлд бүртгэж авсан байна. Мөн автомашины дундаж хурд хэмжих камер, түүний дагалдах хэрэгсэл 62.5 сая төгрөгийн хөрөнгийг ЦЕГ-аас хүлээж авсан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,128.5 сая төгрөгийн 21 орлогын гүйлгээ, өмч хөрөнгө, төсөв зарцуулах 22 тушаал, шийдвэрийг байршуулахаас бүх мэдээллийг хугацаанд нь байршуулахаас 6 тушаалыг хугацаа хоцроож байршуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны мэдээллийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн актын хэрэгжилтийн биелэлт, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзэх шаардлагатай.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 2.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2.5 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулсан

Залруулсан алдаа

1. 0.3 сая төгрөгийн ажил гүйлгээг НББ-т өглөг авлагын дансаар бүртгэхгүй шууд зардалд бүртгэсэн байна.
2. Шилэн дансанд өмч хөрөнгө, төсөв зарцуулах 6 тушаалыг байршуулаагүй байна.

8.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ								

8.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	2	2.5	2	2.5	-	-	-	-	-	-
	НИЙТ	2	2.5	2	2.5	-	-	-	-	-	-